



**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

┌ Байгууллагын архивын баримтын ┐
тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 24 дүгээр зүйлийн 24.2, Үндэсний архивын газар /хуучин нэрээр/-ын даргын 2007 оны 59 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 4.7, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/688 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус байгууллагын архивын баримтыг нэгдсэн тоо бүртгэлд хамруулах, тэдгээрийн тоо хэмжээг гаргах, хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг шалгаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор архивын баримтын нэгдсэн тооллогыг 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Архивын баримтын нэгдсэн тооллогыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд:

Тооллогын комиссын ахлагч:
Нарийн бичиг
Гишүүд

М.Цогзолмаа /Мэргэжилтэн/
Н.Өлзийжаргал /Мэргэжилтэн/
Г.Бямбасайхан /Мэргэжилтэн/
Б.Түвшинбаяр/Мэргэжилтэн/
Э.Мөнх-Эрдэнэ /Мэргэжилтэн/
А.Намуун /Мэргэжилтэн/
П.Ариунцэцэг /Нярав/

2. Архивын баримтын тооллогыг тогтоосон хугацаанд явуулж дүн мэдээг Нийслэлийн архивын газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /М.Цогзолмаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД